

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХӨА-2022/251/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-эрдэнэ
Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Отгонбаяр
Утас: 89306788 цахим хаяг: otgonbayarde@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
/төгрөгөөр/	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3.Аудитын тайлан	7
3.1. Ерөнхий зүйл	7
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Материаллаг байдал	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал.....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4. Аудитын илрүүлэлт	12
4.1 Залруулсан алдаа	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.21 № 01/93
танай _____ -ны № _____ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Б.ЭРДЭНЭХУЯГ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,934,356,798.00	2,820,527,738.00
33	АВЛАГА	2,934,356,798.00	2,820,527,738.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	30,809,793.00	145,407,055.00
335	Бусад авлага	2,903,547,005.00	2,675,120,683.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,903,547,005.00	2,675,120,683.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,934,356,798.00	2,820,527,738.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,868,950.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,868,950.00	0.00
413	Өглөг	5,868,950.00	0.00
4136	Бусад өглөг	5,868,950.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,868,950.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,928,487,848.00	2,820,527,738.00
51	Засгийн газрын хувь оролцоо	2,928,487,848.00	2,820,527,738.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,928,487,848.00	2,820,527,738.00
51210	Өмнөх үеийн үр дүн		2,909,988,466.00
51220	Тайлант үеийн үр дүн	2,928,487,848.00	-89,460,728.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,934,356,798.00	2,820,527,738.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,092,265,250.00	907,782,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,656,000.00	3,278,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,656,000.00	3,278,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,656,000.00	3,278,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,656,000.00	3,278,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,087,609,250.00	904,504,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	416,955,500.00	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	416,955,500.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	670,653,750.00	904,204,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,290,000.00	13,040,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	656,422,100.00	867,924,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,941,650.00	23,240,000.00
1330	Төсвийн захирагчдаас		300,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		300,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	907,179,361.00	997,243,328.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	907,179,361.00	997,243,328.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,046,150.00	39,328,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000,000.00	9,548,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	9,548,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,046,150.00	29,780,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,941,650.00	10,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,104,500.00	19,780,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	880,133,211.00	957,915,178.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	357,679,734.00	389,639,778.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	357,679,734.00	389,639,778.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	576,000.00	-
213304	Хөрөнгийн	576,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,333,477.00	4,097,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,333,477.00	4,097,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	505,544,000.00	564,178,400.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	505,544,000.00	564,178,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	185,085,889.00	(89,460,728.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	185,085,889.00	(89,460,728.00)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,092,265,250.00	907,782,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,656,000.00	3,278,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,656,000.00	3,278,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,656,000.00	3,278,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,656,000.00	3,278,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,087,609,250.00	904,504,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	416,955,500.00	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	416,955,500.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	670,653,750.00	904,204,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,290,000.00	13,040,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	656,422,100.00	867,924,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,941,650.00	23,240,000.00
1330	Төсвийн захирагчдаас	-	300,000.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг		300,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,613,655,677.00	1,519,840,590.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,613,655,677.00	1,519,840,590.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,046,150.00	39,328,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,000,000.00	9,548,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,000,000.00	9,548,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,046,150.00	29,780,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,941,650.00	10,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,104,500.00	19,780,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,586,609,527.00	1,480,512,440.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,049,679,734.00	797,639,778.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,049,679,734.00	797,639,778.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,656,000.00	51,157,990.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,656,000.00	51,157,990.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,339,366.00	67,536,272.00

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,742,366.00	66,036,272.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,597,000.00	1,500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	523,934,427.00	564,178,400.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	523,934,427.00	564,178,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(521,390,427.00)</u>	<u>(612,057,990.00)</u>
14	Бусад эх үүсвэр	-	612,057,990.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		612,057,990.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	<u>612,057,990.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(521,390,427.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,823,401,959.00	0.00	2,823,401,959.00
C07	Тайлант үеийн үр дүн			105,085,889.00		105,085,889.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,928,487,848.00	0.00	2,928,487,848.00
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,928,487,848.00	0.00	2,928,487,848.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-18,499,382.00	0.00	-18,499,382.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,909,988,466.00	0.00	2,909,988,466.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-89,460,728.00		-89,460,728.00
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	2,820,527,738.00

2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	880,964,200.00	813,427,928.00	67,536,272.00	92.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	880,964,200.00	813,427,928.00	67,536,272.00	92.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,588,150.00	16,088,150.00	1,500,000.00	91.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,040,000.00	11,540,000.00	1,500,000.00	88.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,040,000.00	11,540,000.00	1,500,000.00	88.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	863,376,050.00	797,339,778.00	66,036,272.00	92.35
2132	Бусад урсгал шилжүүлэг	863,376,050.00	797,339,778.00	66,036,272.00	92.35
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	863,376,050.00	797,339,778.00	66,036,272.00	92.35
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	880964200.00	813,427,928.00	67,536,272.00	92.33
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	880964200.00	813,427,928.00	67,536,272.00	92.33
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	867924200.00	801,887,928.00	66,036,272.00	92.39
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	13040000.00	11,540,000.00	1,500,000.00	88.50

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Отгонбаяр, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь Төрөөс баримталж буй хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээг аймгийн хэмжээнд зохион байгуулж холбогдох хууль, журмын хэрэгжилтийг ханган Монгол Улсын хууль тогтоомжоор тогтоосон зорилт, чиг үүргийн хүрээнд “Халамж хүртэгчээс- Баялаг бүтээгч” гэсэн алсын харааг баримтлан үйл ажиллагаа явуулдаг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, журам, зааварт дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай”

2. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01 тоот тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2021-2022 оны хөтөлбөр”-ийг баталсан байна. Тухайлбал:

1. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
2. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр
3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
5. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/289 тоот тушаалаар шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ахplorer 3.65 программ хангамж ашигладаг байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Байгууллагын дотоод хяналт шалгалтыг төлөвлөгөөний дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 1/210 тоот албан тоотоор ирүүлсэн зөвлөмж, Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2021 оны 04 сарын 23-ны өдрийн 372 тоот даалгавар, Захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт хийх журмыг баримтлан 6 чиглэлийн 14 суманд 2 ажлын хэсэг ажилласан байна. Шалгалтын үр дүнд гэрээний хугацаа дууссан, зээлийн эргэн төлөлттэй 113 иргэнтэй 258.5 сая төгрөгийн зөрчилд арга хэмжээ авч тооцоо нийлсэн акт, мэдэгдэл хүргүүлж, 2.5 сая төгрөгийн зөрчлийг шалгалтын явцад арилгуулсан байна.

Тайлант оны эцэст хөтөлбөрт хамрагдсан иргэдийн гэрээний биелэлтийг дүгнэж, эргэн төлөлт болон хэрэгжилтэд түүврээр гүйцэтгэлийн хяналт хийж, зөвлөмж хүргүүлж ажилласан байна. Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал, төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 907.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 18.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 113.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	2,934.3	2,820.5	-113.8
Нийт хөрөнгө	2,934.3	2,820.5	-113.8
Өр төлбөр	5.9	0	-5.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2928.5	2820.5	-108.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2934.3	2820.5	-113.8

/сая төгрөг/

1. Санхүүгийн тайлан дахь нийт хөрөнгийн хэмжээ нь хөтөлбөрүүдийн авлага буурч, татаас санхүүжилтийн авлага өссөнтэй холбоотойгоор 113.8 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.
2. Тайлант онд өр төлбөр 5.9 сая төгрөгөөр буурсан нь санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн нэр, данс зөрүүтэй гүйлгээг залруулсантай холбоотой байна.
3. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,820.5 сая төгрөг болж өмнөх оноос 113.8 сая төгрөгөөр буурсан нь санхүүгийн дэмжлэгийн олголт, өр төлбөр буурсан өөрчлөлттэй байна

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2021 оны А/127 тоот тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны төсвийн нэмэлт санхүүжилтийн хуваарийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний Ерөнхий газрын 2020 оны 06 сарын 23-ны өдрийн 8/1034 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэд сангуудад батлагдсан төсөв байхгүй тул “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай” журмыг зөрчиж байна гэсэн үндэслэлээр дэд сангуудын санхүүжилтийн болон зарцуулалтын эрх нээлгэн төсвийн гүйцэтгэлийг ханган ажиллах чиглэл өгсөн байна. Иймд нэмэлт санхүүжилтийн дансыг шинээр нээлгэсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 5 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийн төв сангаас 867.9 сая төгрөг, бусад санхүүжилтээр Швейцарын хөгжлийн агентлаг, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газраас нийт 23.5 сая төгрөг, Дэлхийн банкны санхүүжилтээр 11.5 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулаагүй төлбөрийн орлого 3.3 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 612.1 сая төгрөг нийт 1,518.3 сая төгрөгийн орлого авч, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд 797.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 39.3 сая төгрөгийг зарцуулж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв санд хөтөлбөрүүдийн эргэн төлөлт болох 681.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Зардлыг 100 хувь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангаас санхүүжүүлсэн байна.

Тухайн байгууллагыг төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр харуулбал:

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээгээр

/сая төгрөг/

№	Хөтөлбөр, арга хэмжээний код, нэр	Зардлын дүн		Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	21-Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээ хангах үйлчилгээ	16.8	16.7	0.1
2	22-Ажилд зуучлах үйлчилгээ	8.4	8.2	0.2
3	24-Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	355.4	336.2	20.0
	Хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ	38.9	38.5	0.4
4	25-Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	18.0	18.0	0
5	26-Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	122.0	120.0	2.0
6	27-Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	167.1	149.5	17.6
7	28-Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	49.8	40.2	9.6
8	30-Хүүгийн хөнгөлөлт	0.7	0.6	0.1

9	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	4.5	4.5	0
10	33-Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт	2.0	1.9	0.1
11	34-Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах	3.5	3.5	0
12	35-Хөдөлмөрийн салбарын ажилтнууд, ХНЗ-ийн 3 талт хорооны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдэх чадавх бэхжүүлэх сургалт	20.0	19.6	0.4
13	39-Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	12.5	12.5	0
14	37-Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ	18.0	17.8	0.2
15	40-Бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр	4.2	4.2	0
16	39-Гарын авлага хэвлэмэл материал	10.2	10.2	0
18	50-Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр	34.8	34.8	0
19	61-Төвлөрүүлэлт	0	681.4	681.4
	Нийт дүн	881.6	1,518.3	636.7

Нэмэлт төсвийн зарцуулалт, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу Төсвийн тухай хуулийн 25.5-д заасан тохиолдолд хандив тусламж авсан эсэх асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайлагнахаар төлөвлөгөөнд тусгасан. Тайлант онд хандив, тусламж аваагүй.

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016-2020 оны үйл ажиллагаанд “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн” сэдэвтэй гүйцэтгэлийн аудит хийхээр 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан.

3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийг түүвэрлэн үзэж горим сорил хэрэгжүүлэхэд алдаатай зүйл илрээгүй болно.

Хөвсгөл аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нэмэлт төсвийн зарцуулалт нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 67.5 сая төгрөгийн ажил үйлчилгээ хэрэгжээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллагын дотоод хяналтаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийн агуулга, стандартад хяналт хэрэгжүүлж гүйцэтгэлийн хувь 93.5 гэж үнэлсэн байна. Аудитаар дахин хянаж үзэхэд гүйцэтгэлийн хувь 97.2 хувьтай байгаа тул Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангалттай гэж үнэллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн нийцлийн хүрээнд аудитаар хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хуулийн нийцлийг авч үзээгүй болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгч биелэлтийг ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу 2022 онд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүн” хийх гүйцэтгэлийн аудитаар тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн гүйцэтгэл, үр дүн, үр өгөөжийг хянах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитын явцад санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнгээр зөрчилтэй асуудал илрээгүй болно.

4.1 Залруулсан алдаа

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд залруулга хийгээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР

Д.ОТГОНБАЯР ОГНОО: